

ШИНЭСТ ХК-НИЙ 2021 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 3-р сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

Бид 2019 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн Мэйжор Дриллинг Монгол ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгыг бүрэн түрээслэж эхлээд жил болж байна. СХД, 32-р хороо, Хуучин Авто худалдааны төвийн ойролцоо байрлах 864м² талбай бүхий сэндвичэн барилгыг түрээслэж зарим тоног төхөөрөмжөө ажилуулж эхлээд байна. Мөн ХУД, 3-р хороонд байрлах Мишгээл Мега Молл ХХК-н талбайд байрлах контейнерыг түрээсэлж бэлэн бүрээгдэхүүнүүдээ тэндээсээ борлуулалт хийж байна. Зарим модон бэлдэц тоног төхөөрөмжөө БЗД-ийн Амгалан гаалийн хяналтын бүсийн хажууд сэндивч түрээслэн хадаглаж байгаа.

Одоогоор бид дахин үйлдвэр барих эсэх, цаашид өөр том объект газар түрээслэх зэрэг асуудлыг судлаж байна. Дэлхийн нийгэд гараад байгаа цар тахал COVID –с үүдэн зах зээл эргэлт муу удааширлалтай байгаа тул бид судалгааны түвшинд ажилаа хийж байна. Түрээслэгч газраас оффисийн барилгын дотор засалыг хийх шаардлага хүргүүлсэн бөгөөд бид эхний ээлжийн дотор засвар үйлчилгээг хийж гүйцэтгээд байсан ба цар тахалтай холбоотойгоор зарим дотор засвар дуусаагүй байна.

Цаашид түрээслэгч байгууллагаас ирсэн саналт хүсэлт засвар үйлчилгээг хийхээр ажиллаж байна. Цар тахалтай холбоотойгоор үйлдвэрлэл зогссонг байдалтай байгаа бөгөөд төлөвлсөн ажил төлөвлөгөөг ч бас удааширлалтай байгаа

Үйл ажиллагаа:

1. Төв замаас манай үйлдвэр хүртлэх 200метр шороон замыг засч засмал зам тавилаа.
2. Хаан банкнаас авсан зээлийн эргэн төлөтөө төлөөд явж байна.
3. ХХБ-с 500,000,000 төгрөгийн бизнесийн зээлийг цар тахалтай холбоотойгоор засгийн газраас гаргасан бизнесээ дэмжих зээлийн эргэн төлөлт хүүг буурлсан бид бүгд хамрагдаж
4. Дулааны шугам сүлжээний насос эвдэрсэнг шинээр авч шаардлагатай бүх засвар үйлчилгээг хийсэн.
5. Бохирын шугамын шахагч насос эвэрсэнг шинээр авч солив.
6. Үйлдвэрийн түүхий эд тээвэрлэх зорилгоор барьж байгуулсан төмөр замыг Эрэл ХХК тасалж өөрсдийн замд ашигласныг шүүхээр шийдвэрлүүлэхээр өргөдөл гаргасан нь шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа.
7. Эрсдлээс урьдчилан сэргийлж Тэнгэр Даатгал ХХК-д үйлдвэрийн болон оффисын барилгуудаа дараах эрсдлээс хамгаалж даатгууллаа.
 - Гал түймэр, дэлбэрэлт
 - Байгалийн гамшигийн бүх эрсдлүүд
 - Ус чийгний нөлөөллийн эрсдэл
 - Цахилгаан эрчим хүчний эрсдэл
 - Цонхны шилний хохирол

Дүгнэлт:

2021 онд Шинэст ХК-ийн үйл ажиллагаанд тодорхой хэлбэрээр ахиц дэвшил гарсан боловч дараах үндсэн зорилгууддаа хүрч ажиллаж чадаагүй.

Үүнд:

- Төлөвлөсөн борлуулалтын орлого биелэгдээгүй
- Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

Шалтгаан нь:

Манай борлуулалт жилээс жилд улам багассаар байна. Иймд бид бүтээгдэхүүнийхээ чанарт илүү анхаарч эхэлсэн. Мөн маркетинг, сурталчилгаа сайн хийж, борлуулалтын сувгаа нэмэхээр ажилласаар ирлээ.

Гэвч манай борлуулалтын орлого байгууллагын сарын зардлыг дөнгөж нөхөхүйц, зарим өвлийн саруудад зээл болон бусад эх үүсвэрээр нөхөж байгаа нь үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах дорвитой шийдэлийг эрэлхийлсээр байна.

ГҮЙЦТГЭХ ЗАХИРАЛ ШИНЭСТ ХК /Э. БОЛОР/

